

АРИЛЖААНЫ БОНУС ХӨТӨЛБӨР - НӨХЦӨЛ БА ЖУРМУУД

А. Танилцуулга

1. Zero Markets ХХК нь Сент Винсент ба Гренадинд (Limited Liability Number 503 LLC 202) бүртгэлтэй компани юм. (Цаашид "Компани" эсвэл "Zero Markets" гэнэ).
2. "Арилжааны бонус хөтөлбөр"-ийн нөхцөл ба журмууд нь "Zero Markets-ийн нөхцөл ба журмууд"-ийн салшгүй хэсэг бөгөөд энэхүү баримт бичигт заасан заалтуудыг "Zero Markets-ийн нөхцөл ба журмууд"-ийн хавсралт гэж үзнэ.

В. Шалгуур

1. Бизнесийн бусад бүх нөхцөл, журмыг харгалзан доор дурдсанчлан энэхүү хөтөлбөрт хамрагдах шалгуурыг хангасан Zero Markets-ийн хэрэглэгчдэд ("Эрх бүхий хэрэглэгчдэд") зориулагдсан болно.
2. "Арилжааны бонус хөтөлбөрийг"-ийг Zero Markets-аас явуулах ба Zero Markets-д лайв арилжааны аккаунт нээлгэсэн хэрэглэгчид, эсвэл тодорхой урамшууллыг санал болгодог вэбсайт болон олон нийтийн сүлжээгээр дамжуулан Zero Markets-д хандсан хэрэглэгчид, эсвэл Zero Markets-ийн үйл ажиллагаа явуулдаг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл болон вэбсайтын санал асуулгаар дамжуулан Zero Markets-д хандсан үйлчлүүлэгчдэд зориулж болно.
3. Zero Markets нь "Арилжааны бонус хөтөлбөр"-ийг бүх хэрэглэгчид эсвэл Zero Markets тохиромжтой гэж үзсэн улс/бүс нутагт явуулна.
4. "Арилжааны бонус хөтөлбөр"-т зөвхөн оршин суугаа улсынхаа хууль тогтоомжийн дагуу хууль ёсны хүчин төгөлдөр гэрээ байгуулах боломжтой хүмүүс оролцох боломжтой. Дээр дурдсан зүйлийг хязгаарлахгүйгээр оршин суугаа улсынхаа хуулиар 18 нас хүрээгүй эсвэл хуулиар насанд хүрээгүй хүмүүс ("Насанд хүрээгүй") "Арилжааны бонус хөтөлбөр"-т оролцох боломжгүй. Хэрэв та насанд хүрээгүй бол "Арилжааны бонус Хөтөлбөр"-т оролцох боломжгүй.
5. "Арилжааны бонус Хөтөлбөр"-т "Хамтрагч/хамаарал бүхий хүн" оролцохыг хориглоно. Zero Markets нь "Арилжааны бонус хөтөлбөр"-т бүртгүүлсэн оролцогчийн мэдээлэл нь өөр оролцогчийн бүртгэлийн мэдээлэлтэй таарч байвал тухайн оролцогчийг шууд хасах эрхтэй. Энэхүү Нөхцөл ба журамд хэрэглэгдсэн "Хамтрагч/хамаарал бүхий хүн" гэсэн нэр томъёонд өөрөөр заагаагүй бол "Арилжааны бонус хөтөлбөр"-ийн оролцогчтой холбоотой аливаа хувь хүн, аж ахуйн нэгжийг илэрхийлнэ:

- a) Ах, эгч, эхнэр/нөхөр, өвөг дээдэс, удам угсаа, эцгийн удам гэх мэт гэр бүлийн гишүүд
 - b) Хөтөлбөрт оролцогч нь нэг эсвэл хэд хэдэн зуучлагчаар дамжуулан шууд болон шууд бусаар хяналт тавьдаг, эсхүл нэг эсвэл хэд хэдэн зуучлагчийн шууд болон шууд бус хяналтан дор байдаг, эсхүл "Бонус хөтөлбөр"-ийн оролцогчтой хамтын хяналтад байдаг хувь хүн, аж ахуйн нэгж бол; "Хяналт" гэсэн нэр томъёо нь ("хяналт тавьдаг" ба "хяналтан дор" гэсэн нэр томъёоны харгалзах утгын хамт) тухайн хувь хүн, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааны бодлогыг чиглүүлэх эрхийг шууд буюу шууд бусаар, энгийн хувьцааг өмчлөх замаар эсвэл нэг болон хэд хэдэн аж ахуйн нэгжээр дамжуулан эзэмшихийг хэлнэ.
6. Түүнчлэн, хэрэв та Zero Markets-ийн эсвэл SNS дээрх Zero Markets-тэй холбоотой тодорхой урамшууллын хөтөлбөрт аль хэдийн оролцсон бол энэхүү "Арилжааны бонус хөтөлбөр"-т оролцох боломжгүй юм. Өөрөөр хэлбэл, та хөтөлбөрт давхцаж эсвэл хоёр ба түүнээс дээш хөтөлбөрт нэгэн зэрэг оролцох боломжгүй гэдгийг анхаарна уу.

С. "Арилжааны бонус хөтөлбөр"-ийн тусгай журмууд

1. Зөвхөн энэ баримт бичигт заасан шалгуурыг хангасан эрх бүхий хэрэглэгчид арилжааны бонус авах эрхтэй болно;
 - ZERO Markets дээр лайв MT4 / MT5, Standard эсвэл Super ZERO данс нээсэн байх
 - Шаардлагатай бүх бичиг баримтыг байршуулсан байх
 - Хамгийн багадаа 200 USD/EUR депозит хийсэн байх
 - Урамшуулал дуусахаас өмнө арилжаа хийсэн байх
 - Нөхцөл ба журмыг уншаад зөвшөөрсөн байх
2. Дараах тохиолдолд хэрэглэгчийг хамрагдах боломжгүй гэж үзнэ:
 - Урамшуулал дуусахаас өмнө арилжаа хийгээгүй
 - Нөхцөл ба журмыг уншаад зөвшөөрөөгүй
 - Хамгийн бага депозитийн шалгуурыг хангаагүй
3. Урамшуулал **2023.01.18-нд** эхэлж, **2025.12.31-ний** 23:59 цагт дуусна. "Арилжааны бонус хөтөлбөр" нь **зөвхөн тодорхой хугацааны депозит хийлтэд зориулагдсан.**
4. Энэхүү "Арилжааны бонус хөтөлбөр"-ийн боломжит кредит бонусыг дараах томъёогоор тооцоолно.

Депозит хийсэн дүн х 100% = Боломжит арилжааны бонус

5. Кредит бонус нь депозит хийх хамгийн бага хэмжээг хангасан тохиолдолд харилцагчийн хүсэлтийн дагуу нэмэгдэх бөгөөд арилжааны данс бүрт нийт

50,000 ам.доллараас хэтрэхгүй олгогдох болно.

6. Хэрэглэгч депозит дүнгээ алдсан тохиолдолд нэмэлт алдагдлыг кредит бонус нөхөхгүй. Хэрэв хэрэглэгчийн **Equity** нь **кредитийн** хэмжээнээс доош орвол **"Stop Out"** автоматаар идэвхжинэ.

Системийн доголдол гарсан тохиолдолд арилжаагаа зогсоож, шинээр депозит хийх хүртэл бүх позицоо хаах нь хэрэглэгчийн үүрэг юм. Хэрэглэгч зөвхөн кредит ашиглан арилжаа хийх эрхгүй бөгөөд хэрвээ урвуулан ашигласан нь илэрсэн тохиолдолд ZERO нь учирсан хохирлыг нөхөхийн тулд олон дансаар депозит байршуулахыг зогсоох эрхтэй.

D. Бонусын нөхцөл ба хэрэглээний жишээ:

- a. Бонусыг **КРЕДИТ (CREDIT)** болгон байршуулна.
- b. Бонусыг данс хооронд шилжүүлэх эсвэл татан авах боломжгүй.
- c. Бонсын дүнг тэг эсвэл сөрөг үлдэгдэлтэй данснаас арилжаалах боломжгүй
- d. Нэг дансанд ногдох бонусын дээд хэмжээ **\$50,000 (USD/EUR)**-аас хэтрэхгүй.
- e. Бонусын хэрэглээний жишээ:

Жишээ 1: $\$500 \text{ USD анхны депозит} \times 100\% = \$500 \text{ USD арилжааны кредит бонус}$

Жишээ 2: $\$1000 \text{ EUR депозит} \times 100\% = \$1000 \text{ EUR арилжааны кредит бонус}$

Жишээ 3: $\text{Депозит } \$60,000 \times 100\% = \$50,000 \text{ USD}^* \text{ арилжааны кредит бонус}$

**(Нэг дансанд ногдох бонусын дээд хэмжээ \$50,000)*

- f. Бонус ашиглалтын жишээ:

Жишээ А: $\text{Депозит } \$1000 + 100\% = \text{Equity } \$2,000$

Ашиг \$500 байвал:

Шинэ balance is \$1,500

Шинэ equity is \$2,500

Татан авах боломжит дүн \$1,500

(\$1000 бонус нь татан авах боломжгүй)

Жишээ В: $\text{Депозит } \$1000 + 100\% = \text{Equity } \$2,000$

Алдагдал \$500 байвал:

Шинэ balance \$500

Шинэ Equity \$1,500

Татан авах боломжит дүн \$500

(\$1000 бонус нь татан авах боломжгүй)

- g. Бонустай (кредит) данснаас татан авалт хийх:

Хэрэглэгч мөнгө татан авах хүсэлт гаргасан тохиолдолд дансны үлдэгдэлтэй уялдуулан бонусыг тохируулна.

Хэрэв татан авалт хийх нийт дүн нь бонус (кредит)-ээс их буюу тэнцүү байвал бонусын нийт дүнгээс татан авалтын дүнтэй тэнцүү дүнг хасна.

Хэрэв татан авалтын дүн нь кредитийн хэмжээнээс бага байвал дараах томъёог ашиглан таны кредитээс татан авалтын дүнтэй уялдуулан дүйцэх хэмжээний мөнгийг хасна.

(Татан авах дүн / нийт татан авах боломжит дүн) х бонус хэмжээ = % багасна

- h. Оролцогч анхны депозитоо татан авах хүсэлт гаргавал кредит байхгүй болно.
- i. Оролцогч сөрөг үлдэгдлийг дахин тохируулах сонголтыг хүссэн тохиолдолд депозит хийх хамгийн бага шаардлагыг ханган депозит хийх хүртэл бонусыг хасна.
- j. Урамшууллыг эрх бүхий хэрэглэгч зөвхөн нэг удаа авах боломжтой.
- k. ZERO Markets арилжааны данс хооронд дотоод шилжүүлэг хийх тохиолдолд арилжааны бонус нь (i)-д заасны дагуу хасагдана. Дотоод шилжүүлгийн дараа хүлээн авагч данс руу шинэ болон нэмэлт бонус орохгүй.
- l. "Арилжааны бонус хөтөлбөр"-ийн заалтыг Англи хэлнээс өөр хэл рүү орчуулж, буруу орчуулсан тохиолдолд Англи хэл дээрх хувилбар нь үргэлж давуу эрхтэй байна гэдгийг анхаарна уу.

Е. Ерөнхий журмууд

- 1. ZERO MARKETS нь дараах эрхтэй:
 - a. "Арилжааны бонус хөтөлбөр"-т оролцогчийг бүртгэхээс татгалзах, үйл ажиллагаанд саад учруулсан, хөндлөнгөөс оролцохыг оролдсон, нөхцөл ба журмуудыг зөрчсөн, эсвэл Zero Markets-ийн вэбсайт дээр дурдсан "Zero Markets бизнесийн нөхцөл ба журмууд"-ийг зөрчсөн оролцогчийн эрхийг хасах эрхтэй.
 - b. Zero Markets нь арилжааны бонусны цуцлалт эсвэл бууралтын үр дагаврыг ямар ч тохиолдолд хариуцахгүй (stopout гэх мэт).
- 2. Zero Markets нь хэрэглэгчийн "Арилжааны бонус хөтөлбөр"-ийг зогсоох эрхтэй бөгөөд энэ тохиолдолд хэрэглэгчид имэйлээр мэдэгдэх болно.
- 3. Хэрэглэгч mn.support@zeromarkets.com имэйл хаягаар хандан "Арилжааны бонус хөтөлбөр"-өө хүссэн үедээ зогсоож болох ба холбогдох хэлтэс асуудлыг шийдвэрлэж, энэ тухай хэрэглэгчид мэдэгдэнэ.
- 4. ZERO MARKETS нь "Бонус хөтөлбөр"-ийг хүссэн үедээ өөрчлөх болон зогсоох

эрхтэй. Энэ өөрчлөлтийн талаар хэрэглэгчдэд урьдчилан мэдэгдэх ба ZERO MARKETS-ийн вэбсайтад нийтлэх болно. "Арилжааны бонус хөтөлбөр"-ийн оролцогчдод ZERO MARKETS-ийн вэбсайт дээрх эдгээр нөхцөл, журмыг тогтмол шалгахыг зөвлөж байна. "Арилжааны бонус хөтөлбөр"-т оролцсноор та ийм өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрч байна гэсэн үг юм.

5. Арбитраж (эрсдэлгүй ашиг олох гэх мэт), урвуулан ашиглах (зах зээлийн ямар нэгэн эрсдэл хүлээхгүйгээр зөвхөн кредит бонусаар санхүүгийн ашиг олох гэх мэт), залилан мэхлэх зэрэг аливаа шударга бус, сэжигтэй үйлдэл нь кредит бонусыг хүчингүй болгож болзошгүй. Мөн, ZERO MARKETS нь хэрэглэгчийн арилжааны аккаунтыг хаах (түр эсвэл бүр мөсөн), зогсоох, бүх захиалгыг цуцлах, ийм үйл ажиллагаанаас олсон аливаа ашиг, алдагдлыг бүх ашгаас нь хасах эрхтэй. Ийм нөхцөлд ZERO MARKETS нь кредит бонус цуцалсны ямарваа үр дагаврыг хариуцахгүй (stopout гэх мэт).

Эрсдэлийн анхааруулга

Форекс болон CFD арилжаа нь өндөр эрсдэлтэй байх бөгөөд бүх хөрөнгө оруулагч нарт тохирохгүй байх магадлалтай. Манай бүтээгдэхүүний онцлог, түүний хураамж зэрэг нь манай вэбсайтад байгаа холбогдох хууль эрх зүйн баримт бичигт тусгагдсан болно. Бидэнтэй арилжаа хийхээсээ өмнө хууль эрх зүйн баримт бичгүүдийг анхаарч үзнэ үү. Та манай www.zeromarkets.com вэбсайтаас хууль эрх зүйн баримт бичиг болон нууцлалын бодлогыг уншиж, бүрэн танилцана уу.

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧИЙН МЭДЭГДЭЛ

Zero Markets-д бүртгүүлсэн болон бүртгүүлэх бүх мэдээлэл бүрэн бөгөөд үнэн болно. Хэрэв миний нөхцөл байдал Zero Markets-аас тогтоосон хамгийн бага шалгуурыг хангахад нөлөөлж болзошгүй байдлаар өөрчлөгдвөл би Zero Markets-д мэдэгдэхийг зөвшөөрч байна.

Мөн, кредит бонус хөтөлбөрт хамрагдах эрх бүхий хөрөнгө оруулагч гэж ангилагдах нь баталгаагүй ба Zero Markets-ийн үнэлгээнээс бүрэн хамаарна гэдгийг би хүлээн зөвшөөрч байна.